

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234728

МОНГОЛЫН МЭРГЭЖЛИЙН ЧАВХДАСТ ХӨГЖИМЧДИЙН УР
ЧАДВАРЫН ХӨГЖИЛД ЗӨВЛӨЛТИЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН
ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Г.Отгонжаргал
Х.Саранчимэг

Хураангуй: Энэхүү өгүүлэл нь Монгол улсын өрнийн хөгжмийн боловсролын өнөөгийн түвшний суурь, уран бүтээлчдийн мэргэжлийн ур чадвар, үндэсний зарим хөгжимд гарсан хийцийн болон хөг хөглөгөөний өөрчлөлт зэргийн түүхэн замнал хуучнаар ЗХУ-ын мэргэжилтэн багш нарын оролцоотойгоор хэрхэн дамжиж, хөгжсөн тухай судалгаа болно. Энэхүү судалгааг утсан хөгжмийн жишээнд тулгуурлан бичсэн нь Зөвлөлтийн хөгжмийн багш, мэргэжилтнүүдийн гүйцэтгэсэн үүргийг илүү тодруулах таатай нөхцөлийг бүрдүүлсэн юм. Үндсэн агуулгыг монгол хүн өрнийн хөгжим, ноот бичилттэй танилцсан үе (1914-1937) болон монголчууд мэргэжлийн уран бүтээлчийг бага наснаас нь эхлэн бэлтгэх болсон тухай түүхэн онцлогоор хөтлөн бүрдүүллээ.

Тус судалгааны ажлын эх хэрэглэгдэхүүнийг Үндэсний төв архив, Гадаад харилцааны төв архив, БШУЯ-ны архив, соёл урлагийн чиглэлээр гарсан бичиг баримтын эмхэтгэл, Монгол Улсын Консерваторын архивд хадгалагдаж буй баримт болон бусад судалгааны ажлаас эшлэл болгон ашиглалаа.

Түлхүүр үг: өрнийн хөгжим, ноот, ЗХУ-ын мэргэжилтэн, мэргэжлийн хөгжимчин

Монгол хүн өрнийн хөгжим, ноот бичилттэй танилцсан нь. Монгол улсад өрнийн хөгжим Богд хаант Монгол улсын үеэс эхлэн нэвтэрсэн аж. Монгол улс үндэсний тусгаар тогтнолоо зарласан 1911 онд Орос-Монголын найрамдлын гэрээ байгуулахаар очсон Ерөнхий сайд Т.Намнансүрэн тэргүүтэй Монголын төлөөлөгчдийг Оросын хаан Николай II Санкт-Петербург хотод хүлээн авах үедээ үлээвэр хөгжмийн зэмсэг бэлэглэсэн байна. Энэ нь баруун европын хөгжмийн соёлыг Монголд нэвтрүүлэх анхны алхам болсон юм (Цогтгэрэл, Ж. 2011:56). Улмаар өрнийн ноот бичлэг хэрэглэн дадаж, өнөөг хүрчээ.

Монголчууд хөг эгшгийг тэмдэглэдэг тэмдэг, ноот байсан түүхэн тэмдэглэл бий. Энэ талаарх мэдээ XIII зууны үеийн сурвалж болох Юань улсын түүхэд (Саранчимэг, Х. 2014:25) тодорхой бичигдэн тэмдэглэгдсэн. Харин XVIII зууны үед “Чин сүзэгт номун хантангийн “Гүр дууны бичиг” 2.4-р дэвтрүүдэд дууны шүлгийн ард аялгууг нь тэмдэглэхдээ шинээр ноот бичлэг зохион гаргасан” байдаг ба үүнийг “гүр дууны бичиг” (Эрдэнэчимэг, Л. 1995:3) хэмээн нэрлэдэг байжээ.

Оросын үнэн алдартны шашны лам А.А.Кольцов 1914 онд Богд хаант засгийн дэргэдэх цэргийн үлээвэр хөгжмийн есөн хүнтэй хамтлагт өрнийн ноотны анхны мэдэгдэхүүн зааж сургасан (Цогтгэрэл, Ж. 2011:58) гэж өгүүлжээ. Мөн Богд хаант Монгол Улсын Төрийн сүлд дууллыг 1914 оны 11-р сарын 7-нд Богд хааны дэргэдэх 9 хүний бүрэлдэхүүнтэй цэргийн үлээвэр хөгжимчдөөр тоглуулж дуучин Цэрэнсандаваар дуулуулж байсан байна. Хөгжмийн зохиолч нь Одржей Карел Кадлец (1859-1928) Австри-Унгарын эзэнт гүрэн одоогийн Чех улсын нутаг дэвсгэрт төрсөн, Санкт-Петербург хотын Мариин театрын симфони найрал хөгжмийн 1-р хийлч, хөгжмийн зохиолч, удирдаач хүн байв. Тэрээр 1913 оны сүүлээр Петербург хотод ирээд байсан ерөнхий сайд Намнансүрэнгийн хүсэлт, Петербургийн Их сургуулийн Дорно дахины судлалын тэнхимийн санал болгосон “Зуун лангийн жороо луус” аялгуунд хөгжмийг бичиж, үгийг буриад Агваандоржийн бичсэнээр авсан байна. Үүнээс харахад өрнөдийн хөгжмийн эгшиг тэмдэглэгээ Монгол улсад 1914 он гэхэд нэвтэрч эхэлсэн байна. Анхны үлээвэр хөгжмийн хамтлагт ноотны мэдэгдэхүүн зааж байсан Кольцовын тухай “Залуучуудын үнэн” сонины 1970 оны 49-р дугаарт эрдэмтэн геологич Ж.Дүгэрсүрэнгийн дурдатгалд: “1924 оны хавар, биднийг Улаанбаатар хотын дунд сургуулийн 2-р ангид суралцаж байхад манай дуу хөгжмийн багш Кольцов бидэнд дууны ноот заахын хамт, төгөлдөр хуур хөгжмөөр монгол дууны ая дарж өгдөг байлаа” гэж өгүүлжээ. Энэ нь А.А.Кольцов 1914 оноос хойш 10 жилийн хугацаанд анх эхлүүлсэн ажлаа үргэлжлүүлэн хийж улмаар 1924 онд 1-р дунд сургуулийн хүүхдүүдийг өрнөдийн ноотны ухаан, хөгжимтэй танилцуулж байснаар батлагдаж байна. “Оросын нэрт монгол судлаач П.Козловын хээрийн шинжилгээний ангид ажиллаж байсан С.А.Кондратьевээр Улсын Алдарт Гавьяат дуучин М.Дугаржав 1923-1926 онд ноот заалгахын зэрэгцээ өрнө дахины хөгжмийн ноот бичилтэд суралцах чухлыг таниулан түгээсэн хүн” (Батжаргал, Б. 2022.10.23) хэмээн Монголын хөгжмийн түүхэнд зүй ёсоор тэмдэглэгддэг.

Энэ нь Монголчуудардын хувьсгалын эхний жилүүдэд өрнийн ноот бичилтийг хэрэглэж байсныг илтгэж байна. 1929 онд Москва хотын Чайковскийн нэрэмжит хөгжмийн дээд сургуулийн төгсөгч, цэргийн хөгжмийн удирдаач В.А.Лялин Монгол оронд комиссар Ворошиловын даалгавраар ирж (ред. Останина Н.В. 2015.11.18), авьяаслаг цэргүүдийг сонгон үлээвэр найрал хөгжмийн хамтлаг байгуулжээ. Лялин ирэхдээ Ворошиловын бэлэглэсэн үлээвэр найрал хөгжмийн иж бүрдлийг авчирсан нь тухайн үед цэргийн найрал хөгжмийн хамтлаг үүсэхэд томоохон түлхэц болжээ. Тэрээр залуу хөгжимчдөд найрал хөгжмийн удирдаачийн ур чадвар, ноотны анхны мэдэгдэхүүн, хөгжимдөх арга барилыг гүнзгийрүүлэн заасан. Манай улсын хүсэлтээр 1930 онд ЗХУ-аас А.А.Ефремов тэргүүтэй театрын мэргэжилтэн уригдан ирснээр хагас мэргэжлийн байдалтай байсан театрын урлагийг жинхэнэ мэргэжлийн түвшинд хүргэх нөхцөлийг бүрдүүлжээ. Ефремовыг ирэхээс өмнө 1929 онд Улаанбаатар хотын жүжиг хөгжмийн бүлгэмд урлагийн эрдмийн багшаар Иван Павлович Сверкуновыг авч ажиллуулж байсан нь 1929 онд бүлгэмийн гишүүдийн хийсэн нэгдүгээр хурлын тогтоолд хадгалагдан үлджээ. И.П.Сверкунов хэлэхдээ: “Намайг урлагийн эрдэмд боловсорсон хүн гэж гүнээ хүндэтгэн Улаанбаатар хотноо урлагийн эрдэмд сургах, бат бэх суурь тавих үйл хэргийг удирдахыг гуйсан тул дуртайяа

зөвшөөрнө” гэсэн байна (ҮАГ, Улсын төв театр. 1929:6). Харин Ефремов ирснээр нэг жилийн хугацаатай театр урлагийн анхны түр сургууль байгуулагдан уран чадварын хичээл голлон зааснаар, 1931 онд төгсгөн Ардын цэнгэлдэх хүрээлэнтэй нэгтгэж Улсын төв театр байгуулсан нь урлаг, соёлын чухал төв болжээ. Энэ бол орчин цагийн монголын мэргэжлийн театрын түүхэн эхлэл бөгөөд эндээс манай мэргэжлийн жүжигчид, жүжгийн зохиолчид, найруулагчид, театрын зураачид, хөгжмийн зохиолчид, хөгжимчид, дуучид, бүжигчид зэрэг авьяастнууд төрөн гарсан юм. Ур чадвар бүхий жүжигчид бэлтгэсний нэгэн нотолгоо бол 1933 онд Москва хотноо болсон олон улсын театруудын их наадамд монголын театр II байранд орсон явдал юм. Мэргэжлийн театрууд байгуулагдаж, үзүүлэх үзвэрийн бодлоготой уялдан уран бүтээлчдийг бэлтгэхэд зөвхөн бүлгэм, дугуйлангаас гадна мэргэжлийн сургуулиар бэлтгэх шаардлага гарсан аж. Ингээд 1937 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөл “...театрын ажилд туйлын чухлаар холбогдох уран сайхны ажилчдын шинэ хүчнийг төрүүлэх нь онц чухал” (Батжаргал, Б. 2017:10) хэмээн үзэж мэргэжлийн уран бүтээлчдийг бэлтгэх “Уран сайхны сургууль”-ийг байгуулжээ. Сургуулийг элсүүлэн авах комиссын бүрэлдэхүүнд Улсын төв театрын сургагч В.А.Борейшо, театрын орлогч дарга, алдарт гавьяат хөгжимчин Л.Цэрэндорж, алдарт гавьяат дуучин Ж.Дорждавга оржээ (Энэбиш, Ж. 2017:3). Тус сургууль байгуулагдахтай зэрэгцэн 1937 онд “Дуу хөгжмийн анхны өөрөө сурах ноот бичиг” (Лувсанжамц, Мандал, Чижов), 1939 онд “Ноотыг хэрхэн суралцах бичиг” (Энэбиш, Ж. 2017:150) ноот сурах гарын авлага (С.Гончигсумлаа) хэвлэгдсэн байгаа нь монголчууд өрнийн хөгжмийн боловсролыг нэвтрүүлж, түгээх нь нэгэнтээ тодорхой болсныг харуулж байна.

Сонгодог хөгжмийг түгээн дэлгэрүүлэх үйлсэд чухал хувь нэмэр оруулсан хүн бол Минна Давыдовна Берлин-Печникова (1892-1969) юм. Тэрээр Санкт-Петербургийн Консерваторын төгөлдөр хуурын ангийн төгсөгч, гарамгай төгөлдөр хуурч байжээ (сүүлд Казанийн консерваторын дэд захирал, төгөлдөр хуурын танхимын эрхлэгчээр ажиллаж байсан). 1930-1936 онд нөхөр Абрам Львович Берлинийг (эрдэмтэн, тахал судлаач) дагалдан Монголд амьдарч байх хугацаандаа Улаанбаатарт хөгжмийн боловсрол олгох ажлыг зохион байгуулж хөгжмийн дугуйлан, уран сайхны сургуульд ноот заан хичээл өгч байв. Түүний шавь нарын нэг нь алдарт Мөрдорж гуай юм. Л.Мөрдорж гуай өөрийн дурдатгалдаа тэр үед бид ноот мэддэггүй байсан. Харин сонсголоороо шууд зохион тоглох аргыг сайн мэддэг байсан бөгөөд олуулаа хамтран хөгжимдөх үед энэ арга илүү тод илэрдэг байв. “Би ноотны ухааныг манай төв театрт ажиллаж байсан орос эмэгтэй Берлина-Печникова багшаар заалгасан юм. Хөгжмийн өрөөнд нь хүртэл хонож сургууль, давтлага хийдэг байлаа.” (Энэбиш, Ж. 2019:63) Б. Печникова нь монгол ардын дуунуудыг цуглуулан ноотолж хоёр түүвэр болгон хэвлүүлэн гаргасан бөгөөд түүнд хөгжмийн зохиолч М.Дугаржав, алдарт гавьяат дуучин Ж.Дорждавга, шавь Л.Мөрдорж нар дуулж хөгжимдөж Печникова ноотолж байсан байна. Түүний сурган хүмүүжүүлэх гавьяа нь маршал Чойбалсангийн гарын үсэгтэй монгол хэлээр бичсэн олон захидлаар гэрчлэгддэг гэж түүний охин Г.А.Берлина дурсамждаа бичжээ (Yandex.com millattashlar.ru 2023.11.30). Үүнээс үзэхэд алтан үеийн хөгжмийн анхны зохиолчид сонсголоор зохион тоглодог байсан аялгуугаа тэмдэглэн үлдээх, үргэлжлүүлэн бичих анхны

алхамд суралцсан нь хөгжмийн урлагт их шинэчлэлийг авчирч цааш хөгжих үндэс болж өгчээ.

Монголын сонгодог хөгжмийн урлагтай салшгүй холбоотой хүний нэг бол 1940 онд Монгол улсад театрын удирдаачаар ажиллахаар ирсэн Б.Ф.Смирнов (1912-1971) юм. Б.Ф.Смирнов нь хөгжмийн зохиолч, удирдаач, ардын урлаг судлаач, эрдэмтэн багш бөгөөд Петербургийн хөгжмийн дээд сургууль, Гнесений хөгжмийн академийн төгсөгч байжээ. Б.Ф.Смирнов Монгол оронд ирмэгцээ Төв театрын ардын хөгжмийн найралтай ажиллаж ноотны анхны мэдэгдэхүүн заан сургаснаар” хөгжимчид үндэснийхээ аялгуу, дууг өөрсдөө ноотлон тоглодог болсон түүхэн цаг үе эхэлсэн гэж үздэг. Смирнов өрнөдийн ноот заахын хажуугаар хөгжмийн онолын тухай анхны ойлголт өгч, ардын хөгжмийн хөгийг шинэчлэн тогтоосон байдаг. Тэрээр үндэсний хөгжимчдийг давхар сонгодог хөгжимд бие даан суралцуулснаар европ, ардын хөгжим холилдсон анхны оркестр байгуулагдсан юм (Лхагвасүрэн, Д. 2013:51). Ийнхүү Смирнов үндэсний хөгжимчдийг ноотоор тоглох дадалд сургахыг зорьсон нь сонгодог хөгжмийн найрал бүрдүүлэх их ажлын эхлэл болсон. “Дараа нь Б.Смирнов тус театрын дэргэд Композиторуудын семинар нэртэй хичээл эхлүүлжээ. Энэ нь тус улсад үндэсний хөгжмийн зохиолчдыг бэлтгэх ажлын эхлэл байжээ.”(Энэбиш, Ж. 2019:66).

Ардын хувьсгалаас өмнөх жилүүдэд ардын хөгжимчид ялангуяа морин хуурчид, дуучдын хоолойн цар хүрээнд тохируулан хөгжмийг хөглөн тоглодог байжээ. Нэг үгээр хэлбэл тогтсон хөг байхгүй гэсэн үг. Хөг тогтоох оролдлогыг С.Гончигсумлаа гуай хийж байсан ч (Энэбиш, Ж. 2020:60) мэргэжилтэн Смирнов нь морин хуурын хөгийг фа, си бемоль хөгөөр тогтоож өгсөн юм.

Оросын мэргэжилтэн багш нар уригдаж ирсэн үеэс Монголчууд өрнөдийн сонгодог урлагтай гүн гүнзгий танилцаж, урьд өмнө мэддэггүй байсан олон төрлийн хөгжимдөх ур, техникийн өвөрмөц онцлогууд, гүйцэтгэлүүдийн мэдлэгтэй болсон нь 1940-өөд оноос хойших ардын болон сонгодог хөгжмийн уран бүтээлүүдээс харагддаг. Тухайлбал, Б.Дамдинсүрэн “Учиртай Гурван Толгой” дуурь 1942 он, Л.Мөрдорж “Торгууд бүжиг” 1942 он, “Ээрэнцэх бүжгийн аялгуу” 1946 оны бүтээлээс харж болно.

Судалгааг хийх явцад соёлын холбогдолтой материалыг шүүж үзвэл 1943-1945 онуудад УТТ-с ЗХУ-д сонгодог хөгжмийн олон төрлийн хөгжмийн зэмсэг, дагалдах хэрэгслүүдийн захиалга хийж байсан байна. Үүний нэг нь 1945 мэргэжилтэн Смирнов 46 төрлийн, найрал хөгжимд зайлшгүй хэрэгцээт сонгодог хөгжмийн зэмсгийн захиалга өгч хөгжим ангийн дарга Н.Бельский гарын үсэг зурсан байв. (МУҮАГ. Төв театр. 1945:24-25) Д. Лхагвасүрэнгийн эмхэтгэлд энэ тухай: 1946 онд театрын симфони найрал хөгжим бие даасан анхны концерт бэлтгэж Л.В.Бетховены “Хувьсгалт баатарлаг III симфони”, “Эгмонт” удиртгалыг хөгжимджээ. Мөн Ж.Чулуун хийлээр, Г.Жамьян морин хийлээр, Д.Дугарсүрэн кларнет хөгжмөөр гоцлол хөгжмийн номер тоглож симфони найрлыг Б.Дамдинсүрэн удирджээ” (Лхагвасүрэн, Д. 2013:54) хэмээн бичигдсэнийг үзвэл Смирновын захиалгын дагуу ирсэн хөгжмөөр анхны бие даасан уран бүтээл тоглогдсон нь харагдаж байна. Ийнхүү Б.Ф.Смирновын байгуулсан анхны холимог оркестр хүрээгээ тэлж бие даасан симфони найрал хөгжимчдийг бэлдэн,

хөгжимчид ноот унших, ашиглах чадвартай болсныг гэрчилж байна . Ер нь Төв Театрт мэргэжилтэн Н.Бельский, С.Голперин, В.Борейшо, А.Белоусов нар ирснээр үндэсний болон сонгодог хөгжимчдийн үлээвэр, чавхдаст хөгжимчдийн тоглох ур чадвар эрс дээшилсэн. Тус багш нарын үед ноотны онолын мэдэгдэхүүнээс гадна хөгжмийн бүтээлийн илэрхийлэл, төрөл бүрийн техникүүдтэй танилцаж суралцаж эхэлсэн нь уг тоглолтоор нотлогдож, баримтжин үлджээ.

Буриадын дуурь бүжгийн театрынхан 1942 онд Монгол улсад аялан тоглолт хийх хугацаандаа бүх төрлийн хөгжмийн сургалтыг зохион байгуулж байжээ. Б.Болдырев багш манай анхны морин хийл хөгжимчин ТШ, АЖ, алдарт морин хуурч Г.Жамьян (1919-2007), ТШ, МУУГЗ, хөгжмийн зохиолч Э.Чойдог (1926-1988) нарыг бэлдсэн байдаг. Хоёр утастай морин хуур хөгжим тоглож байсан хөгжимчин дөрвөн утастай морин хийл хөгжимд суралцах нь хүнд байсан нь гарцаагүй. Морин хийл, морин хуур хөгжим нь ижил нумт хөгжмийн төрөлд багтдаг боловч хөгжмийн хэлбэр дүрс, утасны бүтэц, хурууны тавилт, хөгжмийн дуугаралтын цар хүрээ зэргээрээ өөр өөрийн онцлог шинжтэй. Жамьян багш морин хийл хөгжимд суралцсан нь өрнийн хөгжмийн хөгжимдөх ур чадварын нарийн техникийн мэдлэгтэй болж улмаар морин хуур хөгжимд хэрэгжиж, нэвтэрч эхэлсэн. Энэ нь тэдний шавь болох орчин цагийн хуурчдын морин хуур хөгжимд зориулсан симфони бүтээлүүд, хөгжимдөж буй хөгжимчдийн техникийн баялаг ур чадвараар нотлогдож байна. Хийл хөгжимд ТШ, АЖ Ж.Чулуун, хошой ТШ, АЖ Б.Дамдинсүрэн нар Буриадын театрын гоцлол хөгжимчин Н.И.Моториноор хийл хөгжим тоглох арга барил, гарын дасгал хөдөлгөөн, техникийн олон нэршил, тоглох аргачлалыг суралцсан байна. Тэр үед Ж.Чулуун, Б.Дамдинсүрэн нар өөрсдөө бие даан хийл хөгжимд суралцаж байсан үе юм. Хийлч Ж.Чулуун нь 1943 онд хоёр улсын театрынхны хамтарсан тоглолтод М.Дугаржавын “Баян монгол” дууг анх симфони найрал хөгжимтэй гоцлон тогложээ. Д.Жаргалын 2017 онд МУК-ын 80 жилийн ойд зориулсан илтгэлд “Ж.Чулуун, Б.Дамдинсүрэн нар баруун европын хөгжмийн уламжлалт хөгжимдөх арга барилыг монгол үндэсний аялгуутай хослуулан урьд хожид байгаагүй шинэлэг бүтээлийг бий болгосон юм” гэж дурдагджээ. 1944 онд УАСХЭГ-ын даргаас заасан 74-р тушаалд найруулагч, хөгжмийн удирдаач нарын семинарыг явуулах тухай заагджээ. Уг тушаалын 5-р заалтад: “уул семинарт заагдах урлагийн хичээлийн программыг төлөвлөж 9-р сарын 25-ы өдөр Төв театрын ерөнхий найруулагч Оюун, хөгжмийн дерижер Дамдинсүрэн нарт даалгасугай” гэсэн байна. Энэ нь 1944 он гэхэд манай урлагийн хөгжмийн салбарынхан өрнөдийн ноот бичигт суралцсанаар өөрийн уран бүтээлийг туурвих болж улмаар удирдаач, найруулагч нарын хэрэгцээ бий болж, бэлтгэх зорилготой болсныг харуулж байна(ҮАГ. 1944:5). Ж.Чулууны “Ардын хоёр дууны найруулга”, Б.Дамдинсүрэнгийн “Хэнтийн өндөр ууланд” зохиолууд нь өдгөө хүртэл үнэ цэнээ алдаагүй тоглогдсоор байна. Уг зохиолууд нь хийл хөгжимчний эзэмших ёстой төрөл бүрийн техникээр баялаг, орчин цагийн хийлчдийн сонирхлыг татсан уран бүтээл болж чадсан. Ж.Чулууны шавь МУГЖ Д.Цэрэндолгор нь (1931-1965) Монгол Улсад ажиллахаар ирсэн мэргэжилтэн багш И.Я.Белоусов, С.М.Кунаков нараас тоглолтын ур чадвар, олон төрлийн техникийн үзүүлэлтүүд, нюанс, динамик, өнгөний төлөвшил зэрэг арга барилуудад суралцжээ. Тэрээр 1963 онд БНХАУ-д айлчлан тоглолтын үеэр

өөрийн симфони найрал хөгжимтэй Шанхай хотын хөгжмийн зохиолч Хэ Жин Хау, Чен Кай нарын зохиол “Хос эрвээхэй” хийлийн гоцлолыг зохиогчийг нь гайхтал чадварлаг тоглосон түүх өнөөг ч хүртэл дурсагдсаар байна.

Монгол хүн бага наснаасаа эхлэн мэргэжлийн уран бүтээлч (хийлч) болоход бэлтгэгдсэн нь (1937-оноос). Монгол улсад өнөөдөр мэргэжлийн уран бүтээлчийг 6 наснаас нь эхлэн 18 нас хүртэл бага, дунд, коллежийн мэргэжлийн ур чадвар олгодог, үргэлжлүүлэн бакалавр, магистрын зэрэг олгох сургалтыг эрхэлдэг Хөгжмийн дээд сургууль буюу Монгол Улсын Консерватори үйл ажиллагаагаа явуулж байна. Уг сургуулийн түүх бидний энэ удаагийн сэдэв болгон хөндсөн ЗХУ-ын мэргэжилтэн багш нарын үйл ажиллагаатай салшгүй холбоотой юм. Учир нь тус сургууль 1937 онд Театрын дэргэд “Уран сайхны сургууль” нэртэй уран бүтээлч бэлтгэх зорилгоор байгуулагдсан бөгөөд А.Амар сайд тушаалынхаа 11-р зүйлд *“Театрын хөгжмийн ангийн ажлыг шийдвэртэйгээр сайжруулах ба театрын тайз заслалын ажлыг сайжруулахын тулд тусгай хөгжмийн мэргэжилтэн ба тайзны уран зураачийг нэн даруй урьж ирүүлэхийг Гадаад яаманд тушаасугай”* (Батжаргал, Ч. 2017:12) хэмээн тусгайлан заасан байна. Театрт уригдан ажиллаж байсан Б.Ф.Смирнов, Н.Бельский, В.Я.Романовский, С.Гольперин, А.Рабинович, К.Рушев, В.Борешо нар сургуульд хавсран ажиллах болжээ. Энэ үед тус сургууль жүжиг анги, хөгжим анги гэсэн хоёрхон ангитай, 28 сурагчтай, үндсэн багшгүй байж. Үндсэн багшгүйн улмаас хүүхэдтэй ажиллах боломжгүй, орон байрны хүрэлцээ муу учраас суралцах нөхцөл бүрэн хангагдаагүй, 30 хүүхэд авахаас 28 бүрдэж, тэднээс 15 сурагч нь сахилга батгүй, уран чадвар муу авсан, авьяасгүй сурагчид болох тул сургуулийн захиргаа ба Төв театрын сургагч мэргэжилтнээс цөмийг сургуулиас бүрмөсөн гаргах тухай Хүрээлэнгийн даргад мэдэгдэж байсан хатуухан нөхцөл 1937-1938 оны хичээлийн жилийн шалгалтын дүн ба хойшид явуулах ажлын тухай гаргасан акт -д (Батжаргал, Ч. 2017:26) өгүүлсэн нь бий. Мөн Зөвлөлтийн мэргэжилтэн нарын амьдрах орчин, хангамж үйлчилгээ тийм ч таатай бүрдэж чадаагүй нь Урлагийн хэрэг эрхлэх газрын мэргэжилтэн нарын санал хүсэлтээс харагдах ба Маршал Чойбалсан энэ асуудалтай танилцан, өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн байдаг. Ийм нөхцөл байдалд ажиллаж, амьдарч байсан мэргэжилтнүүд үнэнхүү чин сэтгэлээсээ ажиллаж, театрын уран бүтээлийн агуулга, чанарыг сайжруулахад онцгой анхаарч байсныг өнөө ч дурсаар буй. Тэд ардын сайн дурын урлагаас мэргэжлийн хөгжмийн урлагт шилжих ээдрээтэй үед ажилласан юм. Ийм байдлаар эхэлсэн тус сургууль 1950 онд БНМАУ-ын Урлагийн Хэрэг эрхлэх Хорооны тушаалаар (Батжаргал, Ч. 2017:87) үйл ажиллагаагаа өргөтгөн Театр хөгжмийн дунд сургууль болон 1950-1951 оны хичээлийн жилд жүжиг, хөгжим, балет, найрал дууны үндсэн ангиас гадна цирк, дүрслэх урлагийн ангиудыг нээж, 160 сурагчтайгаар хичээлээ эхэлжээ. 1957 оноос тус сургуулийн пианино, скрипкийн ангид 11 жил сургаж, цалин болон тусгай мэргэжлийн диплом олгож байхыг сайд нарын зөвлөлийн тогтоолоор шийдвэрлэжээ. (Батжаргал, Ч. 2017:93) Үүний зэрэгцээ 1957 оноос ХБДС-ийн багшийн хүрэлцээ дутуугаас ЗХУ-аас мэргэжилтэн багш нарыг урин ажиллуулсан ба Кунаков Сергей Митронович нь Төв театрын хийл хөгжмийн багшаар ажиллах болжээ. Энэ үеийг орчин үеийн

мэргэжлийн сургалтыг эхлүүлсэн хэмээн үздэг. Мөн үеэс монголчууд ЗХУ-д эрчимтэй суралцаж эхэлсэн ба төгсөж ирсэн мэргэжлийн хөгжимчид, бүжигчид, кино найруулагч, зураачид цаашдын Монголын мэргэжлийн урлагийн сургалтын үйл ажиллагаагаа бие даан авч явах болсон юм.

Орчин цагийн монголчуудын хөгжим урлалын түүхэнд зайлшгүй тэмдэглэгдэх мэргэжилтэн бол 1967-1968 онд хөгжмийн засвар үйлчилгээ хийхээр томилогдон ирсэн Зөвлөлтийн нэрт хөгжим урлаач, мастер багш **Денис Яровой (1921-1991)** юм. Тэрээр "...ажиллах хугацаандаа нэлээн нухацтай эхлэлийг тавьж 8 хүн сургах, хөгжим хийх багаж зэвсгийн үлгэрийг гаргах, гүйцэтгэсэн ажлын талаар шинжлэх ухааны илтгэл бичих, дуу авианы шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоосон төслийг хийж өгөх, манай оронд ургаж байгаа моднуудын дуу авианы чанарыг тодорхойлж стандарт тогтоож өгөх гэх мэт 6 төрлийн гэрээ" (Яровой, Д. 1968:7) хийжээ. Денис Яровой багш сонгодог хөгжмийн сэргээн засварлах ажлыг Д.Бууранд заан сургасан, улмаар Бууран 1968 онд мэргэжил дээшлүүлэхээр Москвад суралцсанаар Монгол улсын сонгодог утсан хөгжмийн нэрт мастер болсон юм. Яровой нь ХБДС, дуурь, филарманийн хэрэгцээ хангахгүй байгаа хөгжмийг засварлахын зэрэгцээ 10 хөгжим сургуульд хөглөж өгсөн ба түүний хажуугаар ардын ансамблийн хөгжим засварчнаар ажиллаж байв. Д.Яровойн монголчуудад бүтээж өгсөн үнэлж баршгүй гавьяа бол үндэсний морин хуур хөгжмийг орчин үеийн загварт оруулан, акустик хөглөгөөг сайжруулан шинэ төрхийг бий болгосон явдал билээ(Яровой, Д. 1968:8). Энэхүү шинэ үеийн морин хуур хөгжмийг бүтээхдээ тэрээр монголын нэрт хөгжимчин, хөгжмийн зохиолч, удирдаач нар болох Г.Жамьян, Л.Мөрдорж, Б.Дамдинсүрэн, Б.Ренчин (судлаач, зохиолч) нараас морин хуур хөгжмийн тухай нэлээн судалгаа хийж, нүүдлийн уламжлалт соёл, морио дээдлэх монгол хүний сэтгэлгээний онцлогийг хадгалан үлдээхээр ихээхэн хичээл, зүтгэл гаргаснаа тэмдэглэжээ(Яровой, Д. 1968:14). Монголын утсан хөгжмийн хөгжил цэцэглэлд Денис Яровойн бүтээж өгсөн хувь нэмрийн ачаар орчин цагийн хөгжим урлаачид бий болсон билээ.

ЗХУ-ын мэргэжилтнүүд Улаанбаатарт урлагийн сургуулиас гадна мэргэжлийн урлагийн байгууллагад уригдан ажиллаж байжээ. УДБТеатрт 1964 оноос С.С. Садовников, Ю.А. Руколь, 1966 онд А.А. Григорьев уригдан ирж, мэргэжлийн хөгжимчдийн хангалттай хүрэлцээгүйн улмаас 16 хөгжимчнийг бүлгээр нь дагалдуулан сургаж байсан бол, Улсын симфони найрал хөгжимд мэргэжилтэн В.Н. Башмаков хийл хөгжимчидтэй ажиллаж, тоглох ур чадварын түвшнийг дээшлүүлэн сайжруулжээ. Үүний үрээр хөгжимчдийн 73,9 хувь нь мэргэжлийн үнэмлэхтэй болсон байна. Энэ нь хөгжимчид хөгжмийн бага боловсролоос дээш ахиж хөгжмийн дунд боловсролын хэмжээнд ирснийг гэрчилнэ.

1979 онд ХБДС-д уран сайхны удирдагчаар ажиллаж байсан Э.В.Вернигорагийн ажлын тайланг судалж үзвэл, уран сайхны зөвлөлөөс монгол багш нарын тоглолтын ур чадвар, заах аргын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Хөгжмийн Мягмар гараг" тоглолтыг хэрэгжүүлж байв. "Хөгжмийн Мягмар гараг"-нь тоглолтод оролцож буй хөгжимчид, таашаан сонсож буй үзэгч, багш сурагчдад хөгжмийн түүх, онол, хөгжимдөх урлагийн гүйцэтгэлийн ур чадвар, мэдлэгийн цар хүрээг тэлэхэд чиглэсэн соёлын томоохон үйл ажиллагаа болсон гэж дүгнэгдсэн байна. Сурагчдад ганцаарчилсан хичээлээс гадна камерный

ансамбль (дуэт, трио, квартет, квинтет, секстет) хөгжмийн хичээлүүд орж, орчин цагийн сургалтын түвшинд хөгжмийн мэдлэг, мэргэжлийг олж авч байсан нь үүгээр нотлогдож байна. Энэхүү сургалтын үйл ажиллагаа, уран бүтээлийн тайлангийн талаар ЗХУ-ын хоёр мэргэжилтэн багш тайлан бичиж үлдээжээ. Үүнд, хийл хөгжмийн багш Э.Г.Руколь “Начальный период обучение игре на скрипке” (Руколь, Э.Г. 1979:604) хэмээх гарын авлагадаа бага насны хүүхдүүдтэй яаж ажиллах талаар цохон тэмдэглэж, хөгжимдөж сурахад шаардагдах анхны барилт, тавилт, хөгжмийн аялгууны цэвэр өнгийг тогтоолгох аргачлал гэх долоон хуудас дөрвөн хэсэг бүхий заавар зөвлөгөө байна. Харин хийлийн ансамбль, алыт хийл хөгжмийн багш Л.И.Конторовичийн “Задачи организации и методика преподавания ансамбля скрипачей” (Конторович, Л.И. 1979:604) хэмээх тайлан таван хуудас дөрвөн хэсгээс бүрдсэн ба гол агуулгад ансамблийн хичээлд багшаас шаардагдах хүчин зүйлс, суралцагчдын ур чадвар, хөгжмийн илэрхийлэл, техникийн хөгжүүлэлт дээр ажиллах арга зүй, хоолой бүгдийг сонсож сурах, хялбар зөв хурууны дугаар сонгох, цэвэр өнгийг суурьшуулах аргачлалыг багтаажээ. Энэхүү гарын авлага нь багш, суралцагчдад үнэ цэнтэй ховор гарын авлага болж чаджээ.

Монголчууд бид оросын мэргэжилтэн багш нараас олон зүйлийг суралцсанаар өөрийн үндэсний бэлтгэгдсэн боловсон хүчинтэй, сургалтын стандарт шаардлагад нийцсэн хөтөлбөрөөр сургалтаа явуулж 1990 онтой золгосон юм. Энэ хугацаанд мэргэжлийн уран бүтээлч бэлтгэх тус сургууль статусын хувьд цар хүрээгээ тэлсээр байлаа. Монгол оронд ардчилсан хувьсгал ялж нийгмийн шинэ тогтолцооны он жилүүдэд соёлын яам татан буугдаж, урлаг соёлын үйл ажиллагаа орхигдож эхэлсэн хэдий ч сонгодог хөгжмийн үндэсний боловсон хүчин, мэргэжилтэн багш нарын хичээл зүтгэл, уйгагүй хөдөлмөрийн үр дүнд 1992 онд ХБКоллеж болж сургуулийн бүтцэд өөрчлөлт гарав. 1980-аад оны дунд үеэс ЗХУ ба түүний бүрэлдэхүүнд байсан улс орнуудын хөгжмийн дээд сургуулиудаас төгсөгч нар ирснээр шинэ боловсон хүчнээр сэлбэгдсэн ХБДС-ийн утсан хөгжмийн нэгдэл нь сургалтын шинэ систем, хөтөлбөрөөр сургалтаа явуулж эхэлсэн. 2003-2004 оны хичээлийн жилд анхны бакалаврын түвшний эрх авч сургалт явагдан дээд боловсролтой анхны хөгжимчид 2006 оноос төгсөж эхлэв. 2000 оноос утсан хөгжмийн тэнхимийн гадаад харилцаа өргөжин тэлж гадаад орнуудын нэр хүндтэй уралдаан тэмцээнд оролцох болсноор олон улсын түвшинд гарсан сургалтын шинэлэг арга барилаас суралцаж, судалгаа хийсний үр дүнд сурагчдын тоглох ур чадвар дээшлэн, урын санг байнга баяжуулан шинэчилж ирсэн байна. Монгол улс 2015 онд бүх нийтээр 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжиж, ХБК-ын утсан хөгжмийн тэнхимийн сургалтын хөтөлбөрийг бага, дунд, коллеж, бакалаврын түвшинд ахмад багш нарын тусламжтайгаар шинэчлэв. Тус коллеж нь 80 гаруй жилийн хугацаанд 40 гаруй мэргэжлээр 8000 гаруй мэргэжилтэн бэлтгэсэн байна (Шаравцэрэн, Ц. 2018. izvestia.vspu.ru >publics PDF). Ийнхүү коллеж нь сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг шинэчилснээр 2017 онд Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын сайдын А/84 дүгээр тушаалаар ангилал ахиж Монгол Улсын Консерватори болсноор магистрын зэрэгтэй уран бүтээлчдийг бэлтгэх нөхцөлөөр хангагдав. Тус сургуульд төгөлдөр хуур, хийл, морин хийл хөгжимчдийг бага, дунд, коллежийн 12 жил, бакалаврын 4

жил, магистрын 2 жилээр нийт 18 жил хүртэлх хугацаанд сурган, мэргэжлийн уран бүтээлч бэлтгэж байна. Консерватор болох үйл ажиллагаанд ОХУ-ын мэргэжилтний шинжээчийн дүгнэлт ихээхэн тусалсан билээ. Соёл Шинжлэх ухаан, Спортын яамны ажлын хэсэг ОХУ-ын Соёлын яаманд туслалцаа хүсэж, хүсэлт гаргаснаар Санкт-Петербург хотын Н.А.Римский-Корсаковын нэрэмжит хөгжмийн дээд сургуулийн ректорын орлогч Д.Н.Быстров (2017.06.17) хүрэлцэн ирж сургалтын үйл ажиллагаатай танилцжээ. Быстров ХБК-ийн орчин, хөтөлбөр, мэргэшил, материаллаг техникийн бааз, төгсөгчдийн ажиллах нөхцөл, мэргэжлийн урлагийн байгууллагуудын бодит байдалтай танилцан, коллежид багшилж буй багш нарын ур чадвар дэлхийн жишгээс дутуугүй болохыг, сургалтын хөтөлбөр төлөвлөгөө мэргэжлийн уран бүтээлч бэлтгэхүйц сайн боловсрогдсон, суралцах орчин нөхцөл хангалттай бүрдсэнийг цохон тэмдэглэж, боловсролын сайд тэргүүтэй эрх бүхий албан тушаалтан нарт шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлсэн юм (Батжаргал, Ч. 2017:274). Ийнхүү Монгол улсад сонгодог хөгжмийг хөгжүүлэх үйлсэд тулгийн чулуу тавилцсан Оросын мэргэжилтэн багш нарын гавьяа зүтгэл их бөгөөд тэдний бидэнд өвлүүлэн үлдээсэн сургалт, сурган хүмүүжүүлэх ухаан улам баяжин шинэчлэгдсээр дэлхийн хэмжээнд өөрийн гэсэн орон зайг бүрдүүлсээр байна.

Дүгнэлт

Бид энэхүү сэдвийг хөндсөнөөр ЗХУ-БНМАУ-аас эхлэн ОХУ-Монгол улсын соёл, урлагийн хамтын ажиллагаа өнөөг хүртэл тасралтгүй амжилттай үргэлжилж буйг харж байна. Монголын орчин цагийн хөгжмийн урлаг дэлхийн урлагийн хөгжилтэй эн зэрэгцэн алхах үндэс суурь хуучнаар ЗХУ-тай салшгүй холбоотойгоор барахгүй өрнийн хөгжмийн онол, үндэсний хөгжмийн дэвшилтэт хөгжилд шууд нөлөөлсөн гэж үзэж байна. Тэр дундаа Монгол улсын Консерватори, Оросын үнэн алдартны шашны лам А.А.Кольцов, цэргийн хөгжмийн удирдаач В.А.Лялин, Берлина Печникова, монголчуудтай хамтран ардын дууг анх ноотолж үлдээсэн, Гончигсумлаагийн ардын хөгжмийн хөгийг тогтоох оролдлого, Смирновын өрнийн хөгжмийн онолын тухай өгсөн анхны ойлголт, ардын хөгжмийн хөгийг (морин хуур) фа, си бимоль хөгөөр тогтоосон, Монголын анхны холимог найрал хөгжим бий болсон, ардын хөгжимчид сонгодог хөгжимд давхар суралцсан тухай, анхны композиторуудын хичээл, анхны сонгодог хөгжмийн захиалга түүний үр дүнд бий болсон найрал хөгжимчдийн анхны тоглолт, нэрт хөгжим урлаач Денис Яровойн Монголын хөгжмийн анхны урлаачдыг бэлтгэн, морин хуурын ширэн царыг модоор сольсон нь, А.Страдиварийн хийлийн акустик загварыг морин хуур хөгжимд шингээж өгснийг, ЗХУ-ын мэргэжилтнүүд Улсын Филармони, УДБТеатрын хөгжимчдийн тоглох арга барилыг сайжруулсан, хөгжим заах арга зүй, Зөвлөлтийн сурган хүмүүжүүлэгч багш нарын заах аргын тайлан, Монголын үндэсний сонгодог хөгжмийн багш нарыг бэлдэж байсан, тэдний тоглолтын ур чадвар мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хөгжмийн мягмар гараг концертыг зохион байгуулсан тухай, Монгол улс бүх нийтээр 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжсэн, сургалтын системтэй шинэчлэгдсэн хөтөлбөр, төлөвлөгөөний уламжлалыг цохон тэмдэглэж байна. Өнөөдөр Монгол улсад өрнийн сонгодог хөгжмийн мэргэжлийн салбар эрчимтэй хөгжиж, сонирхон суралцагч, судлагчдын тоо тогтвортой өсөж байгаа нь мэргэжлийн дуучид, балетын бүжигчид, хөгжимчид, хөгжмийн зохиолчдын ур чадварт ч мөн нөлөөлсөн бөгөөд манай улсын өрнийн урлагийн сургалтын үйл ажиллагааны үрээр төрсөн уран бүтээлчид дэлхийн тайзнаа урилгаар тоглож, олон улсын нэр хүндтэй байгууллагуудад уран бүтээлийн ажиллах гэрээ хийж, ажиллах хэмжээнд хүрсэн нь хуучнаар ЗХУ-тай салшгүй холбоотой хэмээн үзэж байна.

Ном зүй

Монгол хэлээр:

- Батжаргал, Б. (2022.10.23) “Монголчууд европ хөгжмийн ноот бичигт хэрхэн суралцсан тухай”, Багшийн сургуулийн 100 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэл. Улаанбаатар хот.
- Улсын Төв Театр. (1929), Улаанбаатар хотын жүжиг хөгжмийн бүлгэмийн гишүүдийн 1-р хурлын тогтоол. УАГ. Х-13. Д-1. ХН-6. УБ.
- Улсын Төв Театр. (1944). УАСХЭ-ын даргын тушаал №74. УБ. УАГ. Х-13. Д-1. ХН-93. х5.
- Улсын Төв Театр. (1945) УХЭГ-ын гадаад дотоод захиалга. СОВМОНГТУНТОРГ. УБ. УАГ. Х-13. Д-1. ХН-114
- Гадаад мэргэжилтний бүртгэл. (1960-1983).УБ. УАГ, Х-13. Д-2. ХН-745. х.65
- БНМАУ-ын Соёлын яам, гадаад харилцааны хэсэг. (1962-1977). УБ. УАГ. Х-13. Д-2. ХН-472
- Батжаргал, Ч. (2017). Уран сайхны сургуулиас Консерватор хүртэлх 80-н жилийн намтар түүхийн ойллого оршвой. Ред. Саранчимэг, Х. УБ.
- Жаргал, Д. (2017). ХБК-ын 80 жилийн ойд зориулсан илтгэл, Улаанбаатар.
- Их урлагийн түүх, Уран бүтээлийн товчоон. Эмхт. Лхагвасүрэн, Д. (2013). УДБЭТ 50 жил. УБ
- Саранчимэг, Х. (2014). Юань улсын үеийн ордны монгол бүжиг судлал. Хөх хот.
- Диссертацийн ажил
- Цогтгэрэл, Ж. (2011). Монголын цэргийн хөгжмийн үүсэл хөгжлийн судалгаа.
- Диссертацийн ажил. УБ.
- Энэбиш, Ж. (2019) Лувсанжамбын Мөрдорж. Боть I. УБ.
- Энэбиш, Ж. (2019). Билэгийн Дамдинсүрэн. Боть II. УБ.
- Эрдэнэчимэг, Л. (1995). Монгол гүр дууны бичиг. УБ

Гадаад хэлээр:

- Конторович, Л.И. (1979). Задачи организации и методика преподавания ансамбля скрипачей. Гадаадын мэргэжилтний тайлан. УБ. УАГ. Х-13. Д-1. ХН-604.
- Руколь, Э.Г. (1979). Начальный период обучение игре на скрипке. Гадаадын мэргэжилтэний тайлан. УБ. МУУАГ, Х№13, Д№1, 604-р хадгаламжийн нэгж.
- Яровой, Д. (1968). Морин хуур, аргал-хийл (хуучир) хөгжмүүдийн талаар бичсэн реферат, холбогдох баримт. Соёлын Яам. Гадаад харилцааны хэлтэс. УБ. УАГ. Х-13. Д-1. ХН-908

Цахим:

- Ред. Останина Н.В. (2015), Народная культура Приангарья. “Помочь сражаться на культурном фронте”. www.baikalprint.ru, Иркутск.
- Yandex.com millattashlar.ru 2015.03.30, Воспоминания дочери Минны Давыдовны Берлин-Печниковой [Категория Санкт-Петербург]
- Шаравцэрэн, Ц. (2018). Вклад России в развитие высшего образования современной Монголии. Известия ВГПУ. <https://izvestia.vspu.ru> > public PDF

Abstract

This paper is a study on the foundation of the western music education in Mongolia, the professional skills of artists, and the chronology of changes occurred on the design and development in some national musical instruments and how it was transmitted and developed with the participation of expert teachers of the former Soviet Union. This study was written based on examples of string instruments, which created favorable conditions for clarifying the role played by Soviet music teachers and experts.

The main content of this paper consists of the period of introduction of western music and western music sheet in Mongolia (1914-1937) and the period which Mongolians began to train professional artists from an early age.

The original materials of the research work have been used as references from the National Central Archives, the archives of the Ministry of Foreign Affairs and Ministry of Education and Science, archives of National conservatory of Mongolia and other compilation of documents published in the field of culture and art.

Keywords: western music, notes, Soviet experts and professional musicians

ЗХУ-ын мэргэжилтэн багш нарын нэрс:

Кунаков Сергей Митронович – хийл. Улсын Төв Театр 1957 – 1960
Бронин Володарь Петрович – хийл. ХБДС 1957 – 1960
Гаврилов Александр Михайлович – хийл. ХБДС 1959 – 1962
Никишин Анатолий Васильевич – эрдүү хийл. ХБДС 1959 - 1964
Плясков - хийл. ХБДС 1960
Григорьев А.А – хийл. УДБТ 1960 - 1962
Садовников С.С – хийл. УДБТ 1964 - 1966
Башмаков Валерий Николаевич - хийл. Улсын филармони 1960 – 1962
Югов Евгений Леонидович – хийл. ХБДС 1962 – 1964
Зайцева Муза Александрова – виолончель. ХБДС 1962 – 1965
Векслер Моисей Павлович – хийл. ХБДС 1962 – 1964
Горсетман Михаил Исаакович – хийл. ХБДС 1962 – 1964
Гран Георгий Александрович – эрдүү хийл. ХБДС 1965 – 1967
Вестель Михаил Тимокивич – хийл. ХБДС 1965 – 1967
Вестель Михаил Гильтореевич – хийл. ХБДС 1965 – 1967
Савва Николай Александрович – хийл. ХБДС 1965 – 1967
Руколь Элла Григорьевна – хийл. ХБДС 1965 – 1967
Погосян Рубин Геворкович – хийл. ХБДС 1965 – 1967
Фурман Борис Михайлович – хийл. ХБДС 1965 – 1967
Руколь Юрий Андреевич – хийл. ХБДС 1965 – 1967
Сорокина Юлия Димитрова – хийл. ХБДС 1966 – 1968
Горелик Георгий Ильич – хийл. ХБДС 1966 – 1968
Горсетман Михаил Исаакович – хийл. ХБДС 1966 – 1968
Ульянова Тамара Матвеевна – контробасс. ХБДС 1966 – 1968
Яровой Денис Владимирович – хөглөгч. ХБДС 1966 – 1968
Мармурштейн Эмилия Абрамова – эрдүү хийл. ХБДС 1967 – 1969
Мармурштейн Эмилия Геселевич – виолончель. ХБДС 1967 – 1969
Югов Евгений Леонидович – хийл. ХБДС 1968 – 1972
Ефимов Анатолий Иванович – виолончель. ХБДС 1970 – 1972
Конторович Леонид Исаакович – эрдүү хийл, хийл. ХБДС 1970 – 1973
Едигорян Мкртыч Гарегинович – хийл. ХБДС 1970 – 1972
Понаморев Лев Саввич – контробасс. ХБДС 1971 – 1974
Наумец Алексей Саввич – хийл. ХБДС 1972 – 1975
Горбенко Сергей Димитреевич – хийл. ХБДС 1972 – 1975
Катамадзе Евгений Иванович – хийл. ХБДС 1974 – 1976
Комарницкий Александр Александрович – хийл. ХБДС 1975
Султанян Артур Артюнович – эрдүү хийл. ХБДС 1974
Яцынич Андрей Степанович – контробасс. ХБДС 1974- 1976
Сумина Светлана Васильевна – хийл, эрдүү хийл. ХБДС 1975 – 1977
Чубарова Наталья Андреевна – хийл. ХБДС 1975 – 1976

Руколь Юрий Андреевна – хийл. ХБДС 1977 – 1979
Руколь Элла Григорьевна – хийл. ХБДС 1977 – 1979
Конторович Леонид Исаакович – эрдүү хийл. ХБДС 1977 - 1979
Мельник М.И – хийл. ХБДС 1983 – 1984
Мельник Т.А – хийл. ХБДС 1983 – 1984
Миронов – контробасс. ХБДС 1983 – 1984
Лузанова Н.Ф – арфа. ХБДС 1983 – 1984”